



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2015 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 443


Улаанбаатар хот

“Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1.7, 63.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журам нь 2016 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд холбогдох мэдээллийг тогтмол мэдээлж байгаа эсэхэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/, “Монголын хөрөнгийн бирж” ХК /М.Болор/-т тус тус үүрэг болгосугай.
3. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Хорооны 2013 оны 505 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”-ыг хүчингүй болгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлж ажиллахыг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд даалгасугай.

ДЭД ДАРГА



Б.БАТБОЛД

001200

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ЖУРАМ



НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь үнэт цаас гаргагч /цаашид “компани” гэх/-ийн хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагааны талаарх болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Компани нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон энэ журамд заасан мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэд нийтэд мэдээлэх үүрэгтэй.

1.3. Компани нь энэ журмын 1.2-д заасан аливаа мэдээллийг Монгол хэлээр хүргэх ба уг мэдээллийг өөрийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд хүргэнэ. Компани нь шаардлагатай гэж үзвэл гадаад хэлээр мэдээллийг нийтэд хүргэж болно.

1.4. Мэдээллийг нээлттэй болгох ажиллагааг компанийн төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-ийн нарийн бичгийн дарга гүйцэтгэнэ.

1.5. Энэ журамд заасан дараах нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно:

1.5.1. “мэдээллийг нийтэд хүргэх” гэж компани нь холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасан мэдээллийг өөрийн компанийн болон хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд хүргэхийг;

1.5.2. “тухай бүр мэдээлэх” гэж энэ журамд заасан тухай бүр мэдээлэх мэдээллийг тухайн үйл явдал болсон даруй холбогдох журмын дагуу нийтэд мэдээлэхийг;

1.5.3. “дотоод мэдээлэл эзэмшигч” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 77.1-д заасан этгээдийг;

1.5.4. “давхар бүртгэл” гэж гадаад улсын хөрөнгийн биржид үндсэн бүртгэлтэй компанийн үнэт цаасыг Монгол Улсын үнэт цаасны нэгдсэн бүртгэлд бүртгэж, арилжахыг;

1.5.5. “хугацаат тайлан” гэж компаниас хувьцаа эзэмшигчид болон нийтэд мэдээлэл хүргэх зорилгоор энэ журамд заасан өөрийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг бүрэн агуулсан, тодорхой хугацаанд тайлагнах үүрэг бүхий мэдээллийг;

1.5.6. “эрх бүхий албан тушаалтан” гэж Компанийн тухай хуулийн 84.1-д заасан этгээдийг;

1.5.7. “нөлөө бүхий хувьцаа эзэмшигч” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.29-д заасан этгээдийг;

1.5.8. “төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга” гэж Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлд заасан этгээдийг;

1.6. Энэхүү журмын хэрэгжилтэд Хөрөнгийн бирж хяналт тавьж ажиллах бөгөөд хөрөнгийн бирж шаардлагатай гэж үзвэл өөрийн бүртгэлийн ангилал, шалгуурт тохирсон мэдээллийн ил тод байдлыг хангуулахтай холбоотой нарийн дүрэм, журам тогтоож болно.

1.7. Энэ журмаар компанийн нийтэд, тогтмол хүргэх мэдээллийн харилцааг зохицуулах бөгөөд компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл, гарсан шийдвэр, бусад баримт материал, хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайланг холбогдох эрх бүхий байгууллагад хүргэх харилцаа нь үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж болон Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос тогтоосон бусад дүрэм, журмаар зохицуулна.

1.8. Хорооны дэргэд үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэн, хөрөнгө оруулагчдад нээлттэй хэлбэрээр ажиллуулж болно.

ХОЁР. ХУГАЦААТ ТАЙЛАНГ НИЙТЭД МЭДЭЭЛЭХ

2.1. Компанийн хугацаат тайлан нь хагас жилийн болон жилийн үйл ажиллагааны тайлан гэсэн хэлбэртэй байна.

2.2. Компани нь хагас жилийн үйл ажиллагааны тайланг жил бүрийн 8 дугаар сарын 01-ний өдрийн дотор, жилийн үйл ажиллагааны тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор тус тус энэ журамд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

2.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан нь дараах мэдээллийг агуулсан байна:

2.3.1. Компанийн бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл;

2.3.1.1. компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл;

2.3.1.2. компанийн эрхэлж буй үйл ажиллагааны салбарт эзлэх байр суурь;

2.3.1.3. компанийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбогдон үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл;

2.3.1.4. тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаанд гарсан томоохон үйл явдлын талаарх мэдээлэл;

2.3.1.5. компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлын тайлан;

2.3.1.6. нийгмийн хариуцлагын тайлан;

2.3.2. Удирдлагын талаарх мэдээлэл;

2.3.2.1. компанийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт;

2.3.2.2. компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл;

2.3.2.3. компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ, тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны талаарх мэдээлэл;

2.3.2.4. ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны тайлан;

2.3.2.5. гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан;

2.3.2.6. Хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилтийн талаарх үнэлгээний тайлан;

2.3.3. Санхүүгийн байдлын талаарх мэдээлэл;

2.3.3.1. компанийн хагас жилийн санхүүгийн тайлан, санхүүгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ;

2.3.3.2. аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан, түүний тайлбар тодруулга, дүгнэлт;

2.3.3.3. Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээлэл;

2.3.3.4. тухайн жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ болон хувь нийлүүлсэн хөрөнгийн харьцаа;

2.3.3.5. жилийн туршид авсан зээлийн жагсаалт, түүний эргэн төлөлт болон барьцаа, баталгаа гаргасан талаарх мэдээлэл;

2.3.4. Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл;

2.3.4.1. компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал, түүнийшийдвэр;

2.3.4.2. компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч /бенефициар эзэмшигч/ этгээдийн талаарх мэдээлэл;

2.3.4.3. нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл;

2.3.4.4. компанийн эрх бүхий албан тушаалтан болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бусад компанийн хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшдэг талаарх мэдээлэл;

2.3.5. Ногдол ашгийн талаарх мэдээлэл;

2.3.5.1. компанийн ногдол ашгийн бодлого;

2.3.5.2. компанийн тухайн жилд хувиарласан ногдол ашгийн хэмжээ, тарааж буй хэлбэр, хугацаа болон ногдол ашиг хувиарлаагүй тохиолдолд түүний үндэслэл шалтгааны талаарх мэдээлэл;

2.3.6. Бусад шаардлагатай мэдээлэл;

2.3.6.1. энэ журамд заасан тухай бүр мэдээлэх шаардлагатай мэдээлэл;

2.3.6.2. компани шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

2.4. Компани нь хагас жилийн үйл ажиллагааны тайланд энэ журмын 2.3.1.1-2.3.1.4, 2.3.2.1, 2.3.2.2, 2.3.3.1, 2.3.3.3, 2.3.3.5, 2.3.4.1-2.3.4.3, 2.3.5.2-т заасан мэдээллийг тусгасан байх бөгөөд хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд шаардлагатай гэж үзсэн эдгээрээс бусад мэдээллийн тусгаж болно.

2.5. Давхар бүртгэлтэй компанийн хувьд энэ журамд заасан мэдээллийг нийтэд хүргэхдээ цагийн бүсийн зөрүүг харгалзан мэдээллийг нэгэн зэрэг мэдээлнэ.

2.6. Давхар бүртгэлтэй компан нь энэ журамд заасан хагас жилийн болон жилийн эцсийн тайланг Монгол хэл рүү орчуулан нийтэд мэдээлнэ.

ГУРАВ. ТУХАЙ БҮР НИЙТЭД МЭДЭЭЛЭХ МЭДЭЭЛЭЛ

3.1. Компанийн ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдад компанийн бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, түүний эдийн засгийн үзүүлэлт, өмч хөрөнгийн болон удирдлага зохион байгуулалтын бүтэцтэй холбоотой мэдээллийг тухай бүр энэ журамд заасны дагуу нийтэд мэдээлэх үүрэгтэй.

3.2. Компаниас тухай бүр нийтэд хүргэх мэдээлэлд дараах мэдээлэл хамаарна:

3.2.1. Санхүүгийн мэдээлэл;

3.2.1.1. компанийн хөрөнгө, өр төлбөр, хувьцаат капитал болон үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх гэрээ хэлцэл байгуулах;

3.2.1.2. компанийн борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувьд нөлөөлөх бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай байгуулсан гэрээ хэлцлийг цуцлах, дуусгавар болох;

3.2.1.3. компан хөндлөнгийн аудиторын байгууллагатай байгуулсан гэрээ, түүний нэмэлт, өөрчлөлтийн талаарх мэдээлэл;

3.2.1.4. сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэлийн талаарх мэдээлэл;

3.2.1.5. компанийн үл хөдлөх хөрөнгийн үнийн дүнгийн 10 ба түүнээс дээш хувьтай тэнцэх хөрөнгийг худалдах, барьцаалах болон бусад хэлбэрээр бусдад шилжүүлэх, битүүмжлэх, тусгаарлах;

3.2.1.6. компани төлбөрийн чадваргүй болох;

3.2.1.7. компанийн толгой, охин болон хараат компани өр төлбөрөө төлөх санхүүгийн чадваргүй болох;

3.2.1.8. компанийн өрийг хувьцаагаар солих шийдвэр гаргах;

3.2.2. Санхүүгийн бус мэдээлэл;

3.2.2.1. компанийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн, үйл ажиллагаа түр болон удаан хугацаагаар эсхүл бүхэлдээ зогссон;

3.2.2.2. компанийн бизнесийн үйл ажиллагааны зарим хэсгийг охин, хараат компанид болон бусад этгээдэд шилжүүлэх, эсхүл хязгаарлах болсон;

3.2.2.3. компани үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлэх, хувьцааны ханшид нөлөөлөхүйц шинэ бүтээгдэхүүн зах зээлд танилцуулах;

3.2.2.4. үндсэн болон шинэ бүтээгдэхүүнд зориулан тусгай зөвшөөрөл, патент, үйл ажиллагаа явуулах эрх, барааны тэмдэг эзэмших болон цуцлагдах;

3.2.2.5. компанийн оноосон нэр, үндсэн захиргаа болон толгой компанийн оршин байх хаяг байршил өөрчлөгдсөн;

3.2.2.6. компани салбар, төлөөлөгчийн газар байгуулах, татан буулгах болсон талаарх мэдээлэл;

3.2.2.7. компанийн төлөөлөн удирдах зөвлөлболон гүйцэтгэх удирдлагад орсон өөрчлөлт;

3.2.2.8. нийт ажиллагсдын 15 болон түүнээс дээш хувьд өөрчлөлт орох буюу чөлөөлөгдөх, шилжих, шинээр ажилд орох;

3.2.2.9. компани бусад компанийн хувьцааны хяналтын багц болон түүнээс дээш хувийг худалдах, худалдан авах болсон;

3.2.2.10. компанийн борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувийг эзэлдэг үйл ажиллагаатай холбогдох аливаа тусгай зөвшөөрөл /лиценз/ эзэмших болсон эсхүл түүнийг хүчингүй болгосон, барьцаалсан, аливаа хэлбэрээр бусдад шилжүүлсэн;

3.2.2.11. компани шүүхэд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох;

3.2.2.12. хувьцааны опцион болон хувьцаа эзэмшигч компанийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрх бүхий нэмэлт хувьцаа гаргах шийдвэр;

3.2.2.13. компанийг нэгдэх, нийлэх, хувааах, тусгаарлах зэргээр өөрчлөн байгуулах болон өөрчлөх шийдвэр;

3.2.2.14. компанийн хувьцааг хуваах, нэгтгэх тухай шийдвэр;

3.2.2.15. компанийг татан буулгах шийдвэр;

3.2.3. Удирдлагын талаарх мэдээлэл;

3.2.3.1. компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр, хурлын зар, болон хурлаас гарсан шийдвэр, бусад холбогдох баримт материал;

3.2.3.2. компанийн ТУЗ-өөс гаргасан үнэт цаасны ханшид нөлөөлөх аливаа шийдвэр;

3.2.3.3. компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл болон тэдгээрийн бусад компанид эзэмшиж байгаа хувьцаанд гарсан өөрчлөлт;

3.2.3.4. компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орох;

3.2.3.5. компанийн нийт гаргасан хувьцааны хяналтын багц эзэмшигчид болон эрх бүхий албан тушаалтнуудын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон;

3.3. Компани нь энэ журмын 3.2-т заасан аливаа үйл явдал, өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухайн үйл явдал, өөрчлөлт болсоноос хойш ажлын 1 өдөрт багтаан нийтэд мэдээлэх үүрэгтэй.

ДӨРӨВ. НИЙТЭД МЭДЭЭЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

4.1. Энэ журмын 2.3, 3.2-т заасан мэдээллийг өөрийн болон хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах үүргийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга гүйцэтгэх бөгөөд Үнэт цаасны

зах зээлийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-т заасны дагуу мэдээллийн үнэн зөвийг компани хариуцна.

4.2. Компани энэ журмын 4.1-д заасан этгээдийн нэр, албан тушаалыг томилсоноос хойш ажлын 3 хоногийн дотор Хөрөнгийн биржид хүргүүлнэ.

4.3. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь мэдээллийг нийтэд хүргэхдээ компанийн болон хөрөнгийн биржийн цахим хуудсанд тодорхой техникийн туслалцаатайгаар өөрөө байршуулна.

4.4. Хөрөнгийн бирж нь компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргад мэдээлэл оруулах эрх /нууц дугаар бүхий эрх/ өгөх бөгөөд үүгээр дамжин энэ журамд заасан мэдээллийг тухай бүр оруулж ажиллана.

4.5. Хөрөнгийн бирж нь энэ журамд заасан мэдээлэл нийтэд тогтмол хүрч байгаа эсэхэд хяналт тавьж, холбогдох тайланг Хороонд улирал бүрийн дараа сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ.

4.6. Компани энэ журамд заасан мэдээллийг нийтэд хүргэх харилцааг зохицуулсан дотоод журам баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж болно.

4.7. Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага нь компаниас мэдээллийг нээлттэй болгох үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасан хугацаанд үнэн зөв, бүрэн мэдээлж байгаа эсэхэд хяналт тавьж, гарсан үр дагаврыг хариуцна.

4.8. Шаардлагатай гэж үзвэл Хөрөнгийн бирж нь компаниас нийтэд хүргэж буй мэдээлэлд орсон тоон үзүүлэлт, санхүүгийн тайлантай холбоотой мэдээллийг нэмж шаардаж нийтэд танилцуулах болно.

4.9. Хөрөнгийн биржийн цахим хуудсаар нийтэд мэдээлсэн мэдээллээс бусад олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар тархсан цуурхал, худал, ташаа мэдээлэл нь компанийн үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөхөөр бол Хөрөнгийн бирж компаниас нэмж мэдээлэл, тайлбар гаргуулж нийтэд хүргэж болно.

4.10. Хөрөнгийн биржийн цахим хуудсанд олон нийтэд мэдээллэсэн мэдээллийг компанийн албан ёсны мэдээлэл гэж үзэх бөгөөд компани нь бусад олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн хүргэж болно.

4.11. Энэ журмын 2.3, 3.2-т заасан мэдээллийг зохих журмын дагуу нийтэд хүргэх үүргийг биелүүлээгүй компанид Хөрөнгийн бирж зөрчил гарсанаас хойш ажлын 10 өдөрт багтаан шаардлага хүргүүлэх бөгөөд зөрчлийг тогтоосон хугацаанд арилгаагүй тохиолдолд энэ талаарх мэдээллийг Хороонд ирүүлнэ.

4.12. Энэ журмын 2.3, 3.2-т заасан нийтэд хүргэх мэдээллийн нэгдсэн маягт, загварын зааврыг Хөрөнгийн бирж тогтооно.

4.13. Хөрөнгийн биржийн энэ журамд заасан мэдээллийг компани нийтэд тогтмол хүргэх үүргийн хэрэгжилтийг хангуулж байгаа эсэхэд Хороо хяналт тавьж ажиллана.

ТАВ. МЭДЭЭЛЛИЙГ НИЙТЭД ХҮРГЭХЭД ТАВИГДАХ ХЯЗГААРЛАЛТ

5.1. Компанийн дотоод мэдээлэл эзэмшигч нь тухайн мэдээллийг энэхүү журамд заасны дагуу нийтэд мэдээлэхээс өмнө уг мэдээллийг санамсаргүй болон санаатайгаар мэдээлэх, дамжуулах, ашиглах, бусдад олж авах нөхцлийг бүрдүүлэхийг хориглоно.

5.2. Компан нь төөрөгдүүлсэн, хуурамч, бүрэн бус мэдээллийг нийтэд мэдээлэхийг хориглоно.

5.3. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь энэ журмын 4.4-д заасан эрхийг компанийн ТУЗ-ийн зөвшөөрөлгүйгээр бусдад дамжуулах, ашиглуулах, хувийн зорилгоор ашиглахыг хориглоно.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

6.1. Хороо энэ журмын 4.11-д заасны дагуу Хөрөнгийн биржээс ирүүлсэн мэдээллийг холбогдох журмын дагуу хянаж компанийн удирдлагаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу зөрчлийг арилгуулж, холбогдох захиргааны хариуцлага ногдуулна.

6.2. Хороо нь энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 89.1.7-д заасан захиргааны хариуцлага хүлээлгэнэ.